

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/59/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НД	Нийгмийн Даатгал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.25 № 01/112
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Х.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

019020193

бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,966,033.73	173,116,127.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	44,280,662.99	52,024,265.22
312	Банканд байгаа бэлэн мөнгө	44,280,662.99	52,024,265.22
3121	Төгрөг	44,280,662.99	52,024,265.22
31	Төрийн сангийн харилцах	44,280,662.99	52,024,265.22
33	АВЛАГА	328,512.33	8,046,664.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		8,046,664.00
335	Бусад авлага	328,512.33	
3351	Байгууллагаас авах авлага	128,252.33	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	200,260.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	91,356,858.41	113,045,198.39
351	Түүхий эд материал	55,546,699.85	68,841,429.83
35110	Тусгай зориулалттай материал	32,487,735.67	37,476,856.17
35130	Эм боох материал	23,058,964.18	31,364,573.66
354	Хангамжийн материал	35,810,158.56	44,203,768.56
35410	Бичиг хэргийн материал	329,500.00	418,900.00
35420	Аж ахуйн материал	32,642,371.43	40,570,351.43
35440	Түлш шатах тослох материал	179,220.13	0.13
35460	Хүнсний материал	2,328,330.00	2,883,780.00
35470	Бусад хангамжийн материал	330,737.00	330,737.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	412,497,745.71	539,840,076.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	412,497,745.71	539,840,076.11
392	Биет хөрөнгө	382,471,745.71	509,814,076.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	223,209,920.13	344,714,488.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,098,735.84)	(45,710,915.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,054,800.00	115,054,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(91,035,841.67)	(97,168,341.71)
39205	Машин тоног төхөөрөмж	147,875,242.45	178,179,248.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,677,949.07)	(71,292,194.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,573,879.60	47,332,279.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,386,249.89)	(14,334,444.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,000,000.00	53,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(920,524.20)
39217	Номын фонд	959,680.00	959,680.00
393	Биет бус хөрөнгө	30,026,000.00	30,026,000.00
39301	Программ хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,026,000.00	30,026,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	548,463,779.44	712,956,203.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,648,349.00	291,100.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,648,349.00	291,100.00
413	Өглөг	1,648,349.00	291,100.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,357,249.00	
4136	Бусад өглөг	291,100.00	291,100.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	291,100.00	291,100.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	546,815,430.44	712,665,103.72
51	Засгийн газрын хувь оролцоо	195,310,308.92	195,310,308.92
51101	Өмч:-төрийн	195,310,308.92	195,310,308.92
512	Хуримтлагдсан үр дүн	327,097,479.11	492,947,152.39
51210	Өмнөх үеийн үр дүн	327,097,479.11	327,097,479.11
51220	Тайлант үеийн үр дүн		165,849,673.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,407,642.41	24,407,642.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	548,463,779.44	712,956,203.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	595,121,666.44	753,567,388.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,795,386.44	193,182,637.60
120	Нийтлэг татварын бус орлого	145,795,386.44	193,182,637.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,445,000.00	1,000,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	119,426,159.09	171,087,868.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	24,924,227.35	21,094,769.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	449,326,280.00	560,384,751.26
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,021,400.00	26,074,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,021,400.00	26,074,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	432,304,880.00	534,310,751.26
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	432,304,880.00	534,310,751.26
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	476,707,305.30	587,717,715.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,707,305.30	587,717,715.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,707,305.30	587,717,715.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,744,579.36	360,023,868.07
210101	Үндсэн цалин	212,527,724.97	241,990,566.04
210102	Нэмэгдэл	37,739,021.06	82,217,933.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,646,000.00	3,720,000.00
210104	Урамшуулал	15,831,833.33	32,095,368.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,411,010.05	45,437,797.29
210201	Тэтгэврийн даатгал	26,619,302.01	30,974,340.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,697,977.51	3,570,458.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,158,320.41	3,187,024.48
210204	Ажилгүйдлийн даатгал	539,555.10	698,430.13
210205	Эрүүл мэндийн даатгал	5,395,854.02	7,007,543.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,188,267.72	22,269,132.86
210301	Гэрэл, цахилгаан	4,026,113.00	6,562,792.86
210302	Түлш, халаалт	12,221,654.72	15,424,190.00
210303	Цэвэр, бохир ус	940,500.00	282,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,190,800.00	17,932,471.00
210401	Бичиг хэрэг	2,501,900.00	2,564,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,978,900.00	14,047,871.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	710,000.00	970,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		350,000.00
2105	Норматив зардал	61,278,663.73	55,684,318.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,935,802.03	39,552,568.62
210502	Хоол, хүнс	11,324,861.70	16,131,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	532,600.00	417,200.00
210601	Багаж хэрэгсэл	72,600.00	12,200.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	460,000.00	405,000.00
2107	Томилолт, зочны зардал	558,000.00	1,408,000.00
210702	Дотоод албан томилолт	558,000.00	1,408,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		771,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		82,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		164,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		55,000.00
210807	Газрын төлбөр		120,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,803,384.44	83,773,389.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,601,038.00	21,545,746.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	44,202,346.44	62,227,643.60
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		38.14
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		38.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		38.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	118,414,361.14	165,849,673.28
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,479,371.04	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,479,371.04	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,479,371.04)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	114,934,990.10	165,849,673.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	26,760,649.41	83,721,266.90	305,792,225.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн			126,088,215.11	126,088,215.11
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	24,407,642.41	327,097,479.11	546,815,430.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	195,310,308.92	24,407,642.41	327,097,479.11	546,815,430.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			165,849,673.28	165,849,673.28
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	195,310,308.92	24,407,642.41	492,947,152.39	712,665,103.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	475,851,880.00	553,666,599.59
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	475,851,880.00	553,666,599.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,445,000.00	1,328,512.33
120	Нийтлэг татварын бус орлого	1,445,000.00	1,328,512.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,445,000.00	1,328,512.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,445,000.00	1,328,512.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,406,880.00	552,338,087.26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,080,600.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	25,080,600.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,021,400.00	26,074,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,021,400.00	26,074,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	432,304,880.00	526,264,087.26
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	432,304,880.00	526,264,087.26
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	422,996,832.41	527,440,891.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,996,832.41	527,440,891.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,996,832.41	527,440,891.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,009,680.70	360,023,868.07
210101	Үндсэн цалин	161,431,577.22	241,990,566.04
210102	Нэмэгдэл	85,039,154.57	82,217,933.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	3,720,000.00
210104	Урамшуулал	21,002,948.91	32,095,368.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,145,908.71	45,437,797.29
210201	Тэтгэврийн даатгал	23,239,208.74	30,974,340.82
210202	Тэтгэмжийн даатгал	2,726,800.00	3,570,458.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,181,400.00	3,187,024.48
210204	Ажилгүйдлийн даатгал	545,299.97	698,430.13
210205	Эрүүл мэндийн даатгал	5,453,200.00	7,007,543.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,821,400.00	24,873,961.86
210301	Гэрэл, цахилгаан	4,026,113.00	7,989,592.86
210302	Түлш, халаалт	10,854,787.00	16,602,219.00
210303	Цэвэр, бохир ус	940,500.00	282,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,118,900.00	20,814,971.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	2,164,100.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	16,978,900.00	14,047,871.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	940,000.00	1,305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	3,298,000.00
2105	Норматив зардал	48,649,400.00	53,756,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,149,100.00	37,275,400.00
210502	Хоол, хүнс	11,500,300.00	15,739,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		742,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,931,100.00	11,780,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,538,400.00	1,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	10,500,000.00	4,032,200.00
210604	Урсгал засвар	5,892,700.00	6,348,500.00
2107	Томилолт, зочны зардал	558,000.00	1,408,000.00
210702	Дотоод албан томилолт	558,000.00	1,408,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		771,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		82,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		164,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		55,000.00
210807	Газрын төлбөр		120,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,762,443.00	8,573,455.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,762,443.00	8,573,455.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		38.14
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		38.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		38.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,855,047.59	26,225,708.23
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,218,450.00	18,482,106.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,218,450.00	18,482,106.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,218,450.00	18,482,106.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,218,450.00	18,482,106.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,218,450.00)	(18,482,106.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,636,597.59	7,743,602.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,644,065.40	44,280,662.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,280,662.99	52,024,265.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		44,280,662.99	(44,280,662.99)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	627,036,600.00	545,922,959.22	81,113,640.78	87.1%
УРСГАЛ ЗАРДАЛ	627,036,600.00	545,922,959.22	81,113,640.78	87.1%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,036,600.00	545,922,959.22	81,113,640.78	87.1%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,157,000.00	360,023,868.07	72,133,131.93	83.3%
Үндсэн цалин	278,783,700.00	241,990,566.04	36,793,133.96	86.8%
Нэмэгдэл	73,291,000.00	82,217,933.90	(8,926,933.90)	112.2%
Унаа хоолны хөнгөлөлт	4,939,200.00	3,720,000.00	1,219,200.00	75.3%
Урамшуулал	75,143,100.00	32,095,368.13	43,047,731.87	42.7%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	52,989,000.00	45,437,797.29	7,551,202.71	85.7%
Тэтгэврийн даатгал	36,032,200.00	30,974,340.82	5,057,859.18	86.0%
Тэтгэмжийн даатгал	4,239,900.00	3,570,458.43	669,441.57	84.2%
ҮОМШӨ-ний даатгал	3,392,100.00	3,187,024.48	205,075.52	94.0%
Ажилгүйдлийн даатгал	846,200.00	698,430.13	147,769.87	82.5%
Эрүүл мэндийн даатгал	8,478,600.00	7,007,543.43	1,471,056.57	82.6%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,874,000.00	25,423,961.86	(549,961.86)	102.2%
Гэрэл, цахилгаан	6,557,300.00	7,989,592.86	(1,432,292.86)	121.8,
Түлш, халаалт	17,000,000.00	17,152,219.00	(152,219.00)	100.9%
Цэвэр, бохир ус	1,316,700.00	282,150.00	1,034,550.00	21.4%
Хангамж, бараа материалын зардал	21,764,000.00	20,814,971.00	949,029.00	95.6%
Бичиг хэрэг	2,164,100.00	2,164,100.00		100.0%
Тээвэр, шатахуун	14,996,900.00	14,047,871.00	949,029.00	93.7%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,305,000.00	1,305,000.00		100.0%
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийг устгал	3,298,000.00	3,298,000.00		100.0%
Норматив зардал	53,818,100.00	53,756,600.00	61,500.00	99.9%
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,275,400.00	37,275,400.00		100.0%
Хоол, хүнс	15,800,700.00	15,739,200.00	61,500.00	99.6%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	742,000.00	742,000.00		100.0%
Эд хогшил, урсгал засварын зардал	13,460,700.00	12,910,700.00	550,000.00	95.9%
Багаж, техник хэрэгсэл	1,400,000.00	1,400,000.00		100.0%
Тавилга	1,000,000.00	1,000,000.00		100.0%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,032,200.00	4,032,200.00		100.0%
Урсгал засвар	7,028,500.00	6,478,500.00	550,000.00	92.2%

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Томилолт, зочны зардал	1,825,000.00	1,408,000.00	417,000.00	77.2%
Дотоод албан томилолт	1,825,000.00	1,408,000.00	417,000.00	77.2%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	771,500.00	771,500.00		100.0%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	350,000.00	350,000.00		100.0%
Даатгалын үйлчилгээ	82,000.00	82,000.00		100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	164,400.00	164,400.00		100.0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00		100.0%
Газрын төлбөр	120,100.00	120,100.00		100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	25,377,300.00	25,375,561.00	1,739.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	25,377,300.00	25,375,561.00	1,739.00	100.0%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	582,756,000.00	553,666,599.59	29,087,400.41	95.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,074,000.00	26,074,000.00		100.0%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,074,000.00	26,074,000.00		100.0%
НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	556,682,000.00	526,264,087.26	30,417,912.74	94.5%
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	556,682,000.00	526,264,087.26	30,417,912.74	94.5%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		1,328,512.33	(1,328,512.33)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,328,512.33	(1,328,512.33)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		44,280,662.99	(44,280,662.99)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,024,265.22	(52,024,265.22)	
АЖИЛЛАГСДЫН ТОО		21	21	
Удирдах ажилтан		1	1	
Гүйцэтгэх ажилтан		14	14	
Үйлчлэх ажилтан		6	6	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж, орон нутгийн өмчийн эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, бүрэн бүтэн байдал, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих.
- Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил, тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх, зарчимд тулгуурлан шилэн тендер зохион байгуулах.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 20 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 94.58 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 164,492.5 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө	44,280.7	52,024.3	7,743.6
Авлага	328.5	8,046.7	7,718.2
Бараа материал	91,356.8	113,045.2	21,688.4
Үндсэн хөрөнгө	412,497.8	539,840.1	127,342.3
Нийт хөрөнгө	1,853,320.3	1,858,646.0	164,492.5
Өглөг	1,648.4	291.2	(1,357.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	546,815.4	712,665.4	165,849.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,853,320.3	1,858,646.0	164,492.5

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,743.6 мянган төгрөгөөр өссөн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт оны эцэст хийгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 8,046.7 мянган төгрөг болж 7,718.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын дүн байна.

Бараа материал дансны эм боох материал 8,305.6 мянган төгрөг, аж ахуйн материал 7,930.9 мянган төгрөг, бичиг хэргийн материал 89.4 мянган төгрөг, хүнсний материал 555.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 121,507.6 мянган төгрөг, тоног төхөөрөмж 30,304.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,758.4 мянган төгрөг, бусад хөрөнгө 35,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 15,723.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,758.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч,

121,507.6 мянган төгрөгийн барилга байгууламж, 14,580.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 35,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 712,665.4 мянган төгрөг болж 165,492.5 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 490,399.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 24,499.1 мянган төгрөг нийт 514,899.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 514,899.1 мянган төгрөгөөр баталснаас, зардал 67,856.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 582,756.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 67,856.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 526,087.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 26,074.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,328.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 415,501.78 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 74,579.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 491,202.22 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 68,558.10 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80111-Төрийн байгууллагуудын тогтмол зардал	26,074.0	26,074.0		100.0%
1.2	80302-Нэг хүнд ногдох нормативаар тооцсон.	381,857.7	372,678.3	9,179.4	97.6%
1.3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	174,824.3	153,585.7	21,238.6	87.8%
1.4	83603- Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	44,280.7	44,280.7		100.0%
	Дүн	627,036.7	596,618.7	30,418.0	87.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 40,244.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан

авахаар төлөвлөсөн. Үүнд: Хоол хүнс 7,746.0 мянган төгрөг, 18,937.6 мянган төгрөгөөр шатахууныг нээлттэй тендер шалгаруулахаар, 3,560.4 мянган төгрөгийн бичиг хэрэг, урсгал засвар, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 10,000.0 төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр хоол хүнс 15,739.2 мянган төгрөг, 14,047.9 мянган төгрөг, бусад зардал 8,734.6 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь урьд оны ЭМДЕГ-аас 44,280.7 мянган төгрөгийг зардлууд дээр нэмж ЭМЯ-аар суулгуулсан мөн эрүүл мэндийн салбар нь гүйцэтгэлээрээ санхүүждэг болсонтой холбоотой юм. Тогтмол зардал буюу нүүрс 17,152.2 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь үнэ нэмэгдсэнтэй холбоотой.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн М/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 476,707.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 7,150.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,362.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр байр ашиглалттай холбоотой зардлыг 549.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 949.1 мянган төгрөг, нормативд зардлыг 61.5 мянган төгрөг, эд хогшил худалдан аваа зардлыг 550.0 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээ мэдээлэх хугацаа болоогүй, 152 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 3 албан шаардлага, 2 төлбөрийн акт өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 11/35, 11/36, 11/37, 11/38 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	603.4	2	603.4	100%
Албан шаардлага	3	431,435.5	3	431,435.5	100%
Зөвлөмж	3	3,848.7	3	3,848.7	100%
Нийт дүн	8	435,887.6	8	435,887.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 550.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

Мөнгөн гүйлгээний тайлангийн түлш халаалтын 550.0 мянган төгрөгийн зардлыг урсгал засварын зардалд бүртгэн тайлагнасан нь УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 6,416.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 197.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6,219.3 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант ХХОАТ-ын шимтгэлийг тооцоолохдоо 197.2 мянган төгрөгөөр дутуу тооцоолсонд төлбөрийн акт нь УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС 1-д "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандартын заалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Түлш шатахууны тооцоотой холбоотой асуудал.

Илрүүлэлт: Түлш шатахууны тайлан бэлтгэхдээ жолооч нартай спидометрийн заалтаар шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоо бодоогүй 6,219.3 төгрөг байгаа нь УСНББОУС 1-т Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Зам тээврийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

/Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлангийн түлш халаалтын 550.0 мянган төгрөгийн зардлыг урсгал засварын зардалд бүртгэснийг залруулав.	1	550.0			1	550.0	1	550.0				
Дүн	1	550.0			1	550.0	1	550.0				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Татвар суутгаагүй олгосон тэтгэмж	1	197.2	1	197.2								
Түлш шатахууны зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй	1	6,219.3					1	6,219.3				
Дүн	2	6,416.5	1	197.2			1	6,219.3				



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 65-17225502-ТӨА-2024/59/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ХХОАТ-ын суутгалыг 197,196.23 төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан байна.

Энэ нь ХХОАТ-ын 7 дугаар зүйлийн 7.1.1-д ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэж заасныг, Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Г.Даваасүрэнгээр 197,196.23 /Нэг зуун ерэн долоон мянга нэг зуун ерэн зургаан төгрөг хорин гурван мөнгө/ төгрөгийг төлүүлэн Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100140000988 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга Х.Ариун-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Даваасүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019050047